



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/161

Булган

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Хүн ам болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зориулалтаар шинээр инженерийн хийцтэй худаг гаргах /12 ш/ ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: - Ц.Батжаргал

Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: - С.Алтанзул

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

- Н.Пүрэвсайхан

Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар тариалан, техник технологи хариуцсан мэргэжилтэн

Иргэний төлөөлөл: - Х.Баясгалан


Булган сумын иргэн

Нарийн бичгийн дарга: - Г.Давааням

Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо /Ц.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190191